



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 1д сарын 19 өдөр

Дугаар А/689

Есөнбулаг

Гэрээ байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4 дэх заалт, "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 11 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 44 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"- ийн 2.4 дэх зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдаж буй "Туульсын хаан Жангар", Тэмээчдийн баяр-2023 арга хэмжээний шууд дамжуулалтыг гэрээ байгуулан гүйцэтгэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т олгосугай.

2. Гэрээний зардалд шаардагдах 15,000,000 (Арван таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт - шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР